

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2025/12/10

Дуусах хугацаа: 2026/01/10

Ажил эхлэх хугацаа: 2026/01

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, журам, арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, хяналт тавих;
- Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, осол, өвчлөл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, ажилтан болон оюутны аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- ХАБЭА-н сургалт, танилцуулга, үнэлгээ, эрсдэлийн шинжилгээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Ажлын байрны тодорхойлолтод заасан бусад үүргийг гүйцэтгэх.

Тавигдах шаардлага:

- Байгаль орчин, инженерийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- ХАБЭА-н мэргэжлийн сургалтад хамрагдсан, хүчинтэй гэрчилгээтэй байх; (*хэрэв ХАБЭА-н чиглэлээр бакалаврын зэрэгтэй бол мэргэжлийн сургалтын гэрчилгээ шаардахгүй*)
- Мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
- Зохион байгуулах, төлөвлөх, манлайлах болон тайлагнах чадвартай байх;
- Хариуцлагатай, зарчимч, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг байх;
- Англи хэлний ярианы болон бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
- Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар - CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ англи, монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож
ажлын ярицлагад урих болно.